



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/208

Сүхбаатар сум

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

- Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

- Аймгийн Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Зооноз өвчин судлалын төвийн дарга
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга
- Аймгийн Гаалийн газрын дарга
- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга


- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Мал эмнэлгийн газрын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга
- Хилийн 0101-р ангийн захирагч
- Мэдээлэл холбооны сүлжээ ХК-ий захирал
- УБТЗ-ын Сүхбаатар өртөөний дарга
- Сэлэнгэ -Энерго ОНӨААТҮГ-ын дарга
- Урсгал-Ус ХХК-ний захирал
- “Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК-ий Сүхбаатар салбарын дарга
- “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга

2.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, боловсруулан тайланг аймгийн онцгой комисст танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийхэд шаардагдах мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Гамшгаас хамгаалах орон нутгийн албад, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Б. Энхбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш. ОРГИЛ